



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 1/86

Хархорин сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Тус сумын 2,3 дугаар багт байрлах 10 нэгж талбарын 67954м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.
- 2.Газар эзэмшигч Д.Мөнхсайхан, Хархорин интернэшнл ХХК, А.Мэндбаяр, Мойлт Ундрага ХХК, Д.Оюунтөгс, Д.Баярмаа, П.Баярсүрэн, Д.Бат-Очир нарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.
- 3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.
- 4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2025 оны А/08 дүгээр захирамжийн Хархорин интернэшнл ХХК-тай холбогдох хэсэг, 2023 оны А/222 дугаар захирамж, 2019 оны А/55 дугаар захирамж, 2023 оны А/86 дугаар захирамжийн М.Эрдэнэсүрэнтэй холбогдох хэсэг, 2008 оны 199 дугаар захирамж, газар эзэмших эрхийн 0000344188, 0000227235, 0000361564, 0000192533, 0343933 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ



401200171